



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/34

Даланзадгад

Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн шалтгаан хамаарлыг тогтоох баг байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх заалт, Дархлаажуулалтын тухай хуулийн 1.6 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2012 оны А/217 дугаар тушаал, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны А/261 дүгээр тушаал, Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны А/278 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/315, А/316 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн сэжигтэй тохиолдолд ажиллах мэргэжлийн багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, мэргэжлийн багийн гишүүдийн ажиллах журмыг хоёрдугаар, дархлаажуулалтын дараах урвал, хүндрэл /ДДУХ/-ийг тандах журмыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн тохиолдолд гарсан үед багийн гишүүдийг удирдлага мэргэжил арга зүйгээр ханган, авах арга хэмжээг шуурхай зохион байгуулан ажиллахыг Хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсийн хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /С.Сарантунгалаг/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ӨНӨРЖАРГАЛ

C:\Desktop\2020 on TUSHAAL

461290092

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн
А/34 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт



**ДАРХЛААЖУУЛАЛТЫН ДАРААХ УРВАЛ, ХҮНДРЭЛИЙН ШАЛТГААН
ХАМААРЛЫГ ТОГТООХ МЭРГЭЖЛИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Багийн ахлагч: Хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн

Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын менежер

Өрхийн менежер

Хүүхдийн их эмч

Мэдрэлийн их эмч

Клиник лабораторийн их эмч

Мэс заслын их эмч

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн
А/34 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт

ДАРХЛААЖУУЛАЛТЫН ДАРААХ УРВАЛ, ХҮНДРЭЛИЙН ШАЛТГААН
ХАМААРЛЫГ ТОГТООХ МЭРГЭЖЛИЙН БАГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн шалтгаан хамаарлыг тогтоох мэргэжлийн баг нь сэргийлэх тарилга буюу дархлаажуулалтын улмаас хүний эрүүл мэндэд учирсан тогтвортой эсхүл ноцтой хямралд хийсэн шалтгаан хамаарлыг үнэлэн, санал, дүгнэлт, зөвлөмж гаргах үндсэн үүрэг бүхий орон тооны бус бүтэц байна.

Хоёр: Мэргэжлийн багийн үйл ажиллагааны чиглэл

- 2.1. ДДУХ-ийн тохиолдлын мэдээ авмагц Эрүүл мэндийн газрын дарга (хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн, чанарын менежер, өрхийн менежер, хүүхдийн эмч, мэдрэлийн их эмч, клиник лабораторийн их эмч, мэс заслын эмч гэх мэт бусад эмчийн бүрэлдэхүүнтэй) мэргэжлийн багийг ажиллуулна.
- 2.2. ДДУХ-ийн тохиолдолд мэргэжлийн баг нь эмнэлгийн тусламж үйлчилгээ, судалгаа, хариу арга хэмжээнд дүгнэлт хийнэ.
- 2.3. Мэргэжлийн багийн хийсэн дархлаажуулалтын дараах урвал, хүндрэл /ДДУХ/-ийн багц болон хүнд ноцтой тохиолдолд хийсэн тохиолдлын судалгаанд хийсэн дүн шинжилгээний дүнг хэлэлцэн, тэдгээрийн шалтгаан хамаарлын үнэлгээг хийж, санал, зөвлөмж, дүгнэлт гаргана.
- 2.4. Мэргэжлийн баг нь ДДУХ-ийн сэжигтэй өвчтөнд үзүүлж байгаа эмнэлгийн тусламж үйлчилгээг хянаж, шаардлагатай тохиолдолд дараагийн шатны эмнэлэгт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.
- 2.5. Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн багийн гишүүдийг оролцуулан шалтгаан хамаарлыг үнэлэх багийг дахин томилж, үнэлгээнд мэргэжил арга зүйн дэмжлэг тусалцаа үзүүлнэ.
- 2.6. Вакцины чанартай холбоотой асуудлаар үндэсний төвийн эмч, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах;
- 2.7. ДДУХ-ийн тандалтын явцтай танилцан мэргэжлийн арга зүйн зөвлөмж өгөх;

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн
А/34 дүгээр тушаалын гуравдугаар хавсралт

ДАРХЛААЖУУЛАЛТЫН ДАРААХ УРВАЛ, ХҮНДРЭЛ
(ДДУХ)-ИЙГ ТАНДАХ ЖУРАМ

Нэг : Нийтлэг үндэслэл

- 1.1. Дархлаажуулалт хийдэг өмчийн бүх хэлбэрийн эмнэлэг дархлаажуулалтын дараах урвал хүндрэлээс сэргийлэх, илрүүлэх, бүртгэх, мэдээлэх, судлах, тандах үйл ажиллагаанд энэ журмыг мөрдөнө.
- 1.2. Энэхүү журмыг хэрэгжүүлснээр ДДУХ-ээс сэргийлэх, илрүүлэх, бүртгэх, мэдээлэх, тандан судлах, дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаа сайжирна.
- 1.3. ДДУХ гэж дархлаажуулалтын дараа хүний эрүүл мэндэд учирсан тогтвортой, эсхүл ноцтой хямралыг хэлнэ. ДДУХ-ийн шалтгааныг дархлаажуулалтын үйл ажиллагааны алдаа, вакцинаас үүдэлтэй эсвэл эрүүл мэндийн эмгэг байдал нь вакцин тарьсан цаг хугацаатай давхцаж илэрсэн, шалтгаан тодорхойгүй гэж ангилан үзнэ.

Хоёр: Дархлаажуулалт хийдэг эмнэлгийн нярайн болон хүүхдийн эмч нарын гүйцэтгэх үүрэг

- 2.1. Хүүхдэд дархлаажуулалт хийх тохиолдол бүрийн өмнө эрүүл мэндийн үзлэг хийнэ. Эхийн жирэмслэлт, төрөлтийн явц, удмын байдал, хүүхдийн бие сэтгэцийн өсөлт, өвчилж байсан өвчин, урьд нь вакцин тариулсаны дараа урвал хүндрэл илэрч байсан эсэхийг судална. Дархлаажуулалт хийхэд эсрэг заалт байгаа эсэхийг тогтоож, харшлах заалт илэрсэн хүүхдэд эмчилгээ хийж эрүүлжүүлж, цаашид ямар вакцинаар, ямар товлолоор хийхийг тогтоож өгнө.
- 2.2. Мэдрэлийн талаас эмгэгтэй, амьсгалын замын болон бусад өвчнөөр байнга өвчилдөг, урьд нь дархлаажуулсны дараа урвал, хүндрэл илэрч байсан, өндөг болон ямар нэгэн эмийн зүйл хэрэглэсний дараа харшил илэрч байсан хүүхдийг дархлаажуулах асуудлыг шийдвэрлэнэ.
- 2.3. Тухайн хүүхдийг дархлаажуулах талаар хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр, нярайн түүхэнд тэмдэглэл хийнэ. Тухайн өдөр хүүхэд ямар вакцины хэддүгээр тун хийлгэхийг бичнэ.
- 2.4. Өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч нь ДДУХ бүртгэгдээгүй тохиолдолд "0" мэдээг цочмог сул саажилт /ЦСС/ болон тарилгатай халдварт өвчний тандалтын мэдээний хамт 7 хоног бүр дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд утсаар болон цахимаар мэдээлнэ.
- 2.5. ДДУХ илэрсэн үед яаралтай тусламж үзүүлж, шаардлагатай тохиолдолд эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулна.
- 2.6. ДДУХ-ийн тохиолдлын ЭМС-ын 217 дугаар тушаалын гуравдугаар хавсралтын дагуу 24 цагийн дотор дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд утсаар мэдээлнэ.
- 2.7. ДДУХ-ийн тохиолдол бүрийг ЭМС-ын 278 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтын дагуу бүртгэнэ.

- 2.8. ДДУХ-ийн тохиолдол бүрийг ЭМС-ын 217 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын дагуу судалгаа хийж нэг хувийг дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд явуулж, хоёр дахь хувийг байгууллага дээрээ хадгална.
- 2.9. Вакцин, зүү тариураас ЭМС-ын 217 дугаар тушаалын зургаадугаар хавсралтын дагуу дээж авч дархлаажуулалт хариуцсан эмчид хүргүүлнэ.
- 2.10. ДДУХ-ийн сарын мэдээг өргөн дархлаажуулалтын хамралтын мэдээтэй хамт дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд хүргүүлнэ.
- 2.11. ДДУХ-ийн тохиолдол бүртгэгдсэн тухайн сум, орон нутагт олон тохиолдол ажиглагдсан эсэхийг тогтоох идэвхтэй тандалт хийнэ.
- 2.12. Дархлаажуулалтын дараа гарч болох урвал, хүндрэлийн талаар эцэг, эхчүүдэд мэдлэг олгож, илэрсэн тохиолдолд нэн даруй эмнэлэгт хандах тухай зөвлөгөө, зөвлөмж өгнө.

Гурав: Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтний гүйцэтгэх үүрэг

- 3.1. Эрүүл мэндийн газрын дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн ДДУХ-ийн тохиолдол бүртгэгдээгүй тохиолдолд "0" мэдээг цочмог сул саажилт /ЦСС/ болон тарилгатай халдварт өвчний тандалтын мэдээний хамт 7 хоног бүр өрх, сумын эрүүл мэндийн төв, төрөх тасгаас утсаар болон цахимаар хүлээн авсан мэдээллийг нэгтгэн Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалтын албанд утсаар болон цахимаар мэдээлнэ.
- 3.2. ДДУХ-ийн тохиолдлын мэдээ авмагц эрүүл мэндийн газрын дарга нь мэргэжлийн баг (хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн, чанарын менежер, өрхийн менежер, хүүхдийн эмч, мэдрэлийн их эмч, клиник лабораторийн их эмч, мэс заслын эмч гэх мэт бусад эмчийн бүрэлдэхүүнтэй) мэргэжлийн багийг томилон ажиллуулна.
- 3.3. Мэргэжлийн баг нь ДДУХ-ийн тохиолдлын шалтгааныг тогтоох зорилгоор дархлаажуулалттай холбоотой бүх үйл ажиллагааг хянаж нарийвчилсан судалгааг ажлын 3 хоногт багтаан хийж, эхний дүгнэлтийг гарган, мэргэжлийн хяналтын газрын эмчилгээний чанарын хяналтын байцаагчид хүргүүлж ДДУХ-ийн сэжигтэй тохиолдлыг магадлан тогтоолгоно.
- 3.4. Мэргэжлийн баг нь ДДУХ-ийн сэжигтэй өвчтөнийг шаардлагатай тохиолдолд дараагийн шатны эмнэлэгт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.
- 3.5. Вакцин, зүү тариурын сорьц, өвчтөнөөс авсан шинжлэгдэхүүнд лабораторийн шинжилгээ хийлгэж, шинжилгээний хариуг албан ёсоор Халдварт өвчин судлалын үндэсний төвд хүргүүлнэ. Шинжилгээний зардлыг дархлаажуулалт хийсэн эрүүл мэндийн байгууллага хариуцна.
- 3.6. Цаг хугацаа, газар зүйн адил байрлалд нэг төрлийн вакцин тариулсан, ижил шинж тэмдэгтэй ДДУХ-ийн сэжигтэй тохиолдол байгаа эсэхийг илрүүлэх идэвхтэй тандалт (хүүхдийн эмнэлэг, тасагт хэвтэж эмчлүүлж байгаа өвчтөн, өвчний түүх, үзлэгийн журнал, дуудлагын хуудас, хүлээн авахын бүртгэл)-ийг зохион байгуулна.
- 3.7. ДДУХ-ээс сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө зөвлөмжөөр өгнө.